



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Авто зам, замын байгууламжийг түр
хаах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүчтэй цасан шуурганы аюулт үзэгдлийн улмаас авто зам, замын байгууламж цасанд боогдож, тээврийн хэрэгсэл зорчиход хүндрэлтэй нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг учирч болзошгүй гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын чанартай А0301 дугаартай Улаанбаатар-Арвайхээр, А0201 дугаартай Улаанбаатар-Мандалговь, А0202 дугаартай Мандалговь-Даланзадгад, А0501 дугаартай Улаанбаатар-Өндөрхаан, А0502 дугаартай Өндөрхаан-Чойбалсан, А2001 дугаартай Өндөрхаан-Баруун-Урт чиглэлийн авто зам, замын байгууламжийг 2024 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 18 цаг 00 минутаас 2024 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 11 цаг 00 минут хүртэл хааж, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр зогсоосугай.

2. Авто зам, замын байгууламжийг цэвэрлэх ажлыг богино хугацаанд гүйцэтгэж, автотээврийн хэрэгсэл аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг зам хариуцагч "Баянчандмань АЗЗА" ТӨХК (Б.Мөнхгэрэл), "Эрдэнэсант АЗЗА" ТӨХК (А.Баясгалан), "Өвөрхангай АЗЗА" ТӨХК (Д.Лхам-Оролмаа), "Төв АЗЗА" ТӨХК (Д.Болдбаатар), "Дундговь авто зам" ХХК (Х.Баяртогтох), "Авто зам, машин механизм" ХХК (А.Гантулга), "Налайх АЗЗА" ТӨХК (Ц.Баттулга), "Багануур АЗЗА" ТӨХК (М.Мягмаржаргал), "Харгуй АЗЗА" ТӨХК (Л.Бат-Октябрь), "Дорнод авто зам" ХХК (Э.Түвшин), "Талын зам" ХХК (Б.Түвшинмөнх)-д, нэгдсэн шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ (Х.Пүрэвжаргал)-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Авто замын бодлого зохицуулалтын газар (Ч.Сугармаа), Автотээврийн бодлого зохицуулалтын газар (Э.Мөнхнасан), Салбарын хяналтын газар (Б.Бат-Өлзий)-т тус тус даалгасугай.

ДЭД САЙД  ХАЛТАР



080000110